

A close-up photograph of a woman with a joyful expression, smiling as she looks down at a newborn baby. The baby is wrapped in a thick, green and white patterned blanket and is wearing a purple knit hat. The woman is wearing a white shirt. The background is a plain, light-colored wall.

2014 ОНЫ ТАЙЛАН:
Монголд шинэ, бүтээлч аргуудыг
нэвтрүүлэн, тодорхой үр дүнд
хүрч байна

Content

Өмнөх үг.....	1
Суурин төлөөлөгчийн мэндчилгээ.....	2
Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөр: Жирэмслэлт бүр хүссэн, төрөлт бүр эсэн мэнд байх нөхцөлийг бүрдүүлэх нь.....	4
Жендэрийн хөтөлбөр: Хүчирхийллээс ангид, эрх тэгш нийгмийг цогцлоох нь.....	6
Залуучуудын хөгжлийн хөтөлбөр: Монголын залуучуудыг чадавхижуулах нь.....	8
Хүн ам, хөгжлийн хөтөлбөр: иргэн бүрт хүрч үйлчлэх нь.....	11
Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн захиргаа, санхүүгийн хэлтэс шинэлэг санаачилгуудыг нэвтрүүлэв.....	12
2014 оны санхүүгийн товч тайлан.....	13



НҮБ-ын Хүн амын сан
Улаанбаатар, Монгол улс
Веб хуудас: <http://mongolia.unfpa.org>
[Facebook.com/UNFPA.Mongolia](https://www.facebook.com/UNFPA.Mongolia)
[Twitter.com/UN_Naomi](https://twitter.com/UN_Naomi)
Ханливын вэбсайт: www.unfpa-mn.org

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сан хамтран 2012-2016 онд улс орныг дэмжих 5 дахь хөтөлбөрөө хэрэгжүүлж байна. Монгол улс дундаж орлоготой орны ангилалд шилжин, тэргүүлэх чиглэлд нь өөрчлөлт орж, НҮБ-ын Хүн амын сан 2014-2017 онд стратегийн шинэ төлөвлөгөө хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан, хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээний дүнг үндэслэн 2014 оны дундуур уг хөтөлбөрийг дээрх тэргүүлэх чиглэл, стратегид нийцүүлэв.

НҮБ-ын Хүн амын сан нь хүн ам, хөгжил, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрх, залуучуудын хөгжил, жендэрийн тэгш байдал гэсэн дөрвөн үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Хүн ам ба хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хүн амын тоон мэдээ, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийн, бодлого шийдвэр гаргахад ашиглахад нь Засгийн газарт дэмжлэг үзүүлдэг. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хангах хөтөлбөрийн хүрээнд эх, нярайн эндэгдлийг бууруулахад онцгойлон анхаарч, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хэрэглээ, чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлдэг. Залуучуудын хөтөлбөр нь залуучуудыг амьдрах ухаанд сургаж,

чадавхитай, сэтгэлийн хаттай болж төлөвшихөд нь дэмжлэг үзүүлдэг. Жендэрийн хөтөлбөр нь жендэрийн тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэхэд дэмжлэг үзүүлж, жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулахад онцгойлон анхаардаг.

НҮБ-ын Хүн амын сан 1970-аад оны сүүлээс Монгол улстай хамтран ажиллаж, дээрх үндсэн чиглэлүүдэд томоохон өөрчлөлтүүдийг авчрав. Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран Засгийн газрын бодлогуудыг боловсруулж, шинэчлэхэд техник, арга зүйн дэмжлэг үзүүлж, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, эрхийг хангах, чадавхи бэхжүүлэх, түншлэлд зуучлах, эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэлийг ханган нийлүүлэх санаачилгуудыг хэрэгжүүлэв. Эдгээр хөтөлбөрүүд нь эх, нярайн эндэгдлийг 1990 оны түвшингээс бараг талаас илүү хувиар бууруулж, хүн амын тоон мэдээ, мэдээллийг цуглуулж, үр дүнтэй ашиглах найдвартай тогтолцоог бий болгож, жендэрийн тэгш байдал, залуучуудын хөгжлийг хангах чиглэлээр томоохон ахиц гаргахад хувь нэмэр оруулав.



НАОМИ Китахара
НҮБ-ын Хүн амын сангийн
суурин төлөөлөгч

СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

2015 онд НҮБ байгуулагдсаны 70 жилийн ой тохиож, Мянганы хөгжлийн зорилтуудыг (МХЗ) дүгнэнэ. 10 гаруй жилийн тэртээ МХЗ-уудыг хэрэгжүүлж эхэлсэнээс хойш томоохон өөрчлөлт гараад байна. НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Монгол улс Мянганы хөгжлийн 3 (Жендэрийн тэгш байдлыг хангах), 5 (Эхийн эрүүл мэндийг сайжруулах) болон 6 (ХДХВ/ДОХ-той тэмцэх) дахь зорилтуудыг хэрэгжүүлэхэд томоохон амжилтанд хүрлээ. Тухайлбал, Мянганы хөгжлийн 5 дахь зорилтын хүрээнд Монгол улс эхийн эрүүл мэндийг амжилттай сайжруулж, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг дэмжиж, улмаар эхийн эндэгдлийг үлэмж хэмжээгээр бууруулаад байна.

Хүн ам ба хөгжлийн асуудлаарх олон улсын бага хурлаар баталсан Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг биелүүлэхээ НҮБ-ын гишүүн орнууд 2014 онд амласан юм. Монгол улсын тууштай манлайлал, дэмжлэгтэйгээр тус бага хурлаар хувь хүн, ялангуяа залуучууд, эмэгтэйчүүдийн амьдрал, эрхийн асуудалд НҮБ-ын Хүн амын сангаас онцгойлон анхаарах явдлыг улам бүр бататгав.

Өнгөрсөн жилээс НҮБ-ын Хүн амын сан шинэ стратеги төлөвлөгөө хэрэгжүүлж эхэллээ. Хөтөлбөрийг уг стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн, Монгол дахь НҮБ-ын Хүн амын сан доош чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх зарчмаас дээшээ бодлого руу чиглэсэн ухуулга нөлөөллийн зарчим уруу шилжиж байна. Монгол дахь НҮБ-ын Хүн амын сан мөн хувийн хэвшил зэрэг бусад салбаруудтай хөгжлийн шинэ түншлэлийн харилцаа тогтоохыг эрмэлзэж эхэллээ.

Жендэрийн салбарт, 2014 он жендэрийн тэгш байдлыг хангах түүхэн өөрчлөлтийг авчирсан жил байлаа. Монгол Улсын Ерөнхийлөгч НҮБ-ын “АМЛАЛТ” санаачлагад гарын үсэг зурсанаар Монгол улс охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох үүрэг хүлээсэн 64 дэх орон болов. Энэ сацуу НҮБ-ын Хүн амын сан жендэрийн мэдрэмжтэй төсөв боловсруулдаг болоход нь Засгийн газарт дэмжлэг үзүүлж, Японы Засгийн газартай хамтран Улаанбаатар хот болон баруун 3 аймагт гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээ төвүүдийг байгуулах ажлыг зохион байгуулав.

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хангах талаар Эрүүл мэнд, спортын яам Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамжийн стратегийг боловсруулж, 2015 оноос хэрэгжүүлэх гэж байна. Түүнчлэн, Люксембургийн Засгийн газраас Телемедицин төслийг үргэлжлүүлэн санхүүжүүлсэнээр Эрүүл мэнд, спортын яам болон Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран бүх аймгуудад телемедициний сүлжээг байгуулж, эх, хүүхдийн эрүүл мэндийн ажилтан, мэргэжилтнүүдэд зориулсан цахим сургалтын индэрийг бий болгов. Эх, нярайн эндэгдлийг бууруулахад телемедицин сүлжээ бодит хувь нэмэр оруулсан нь дунд хугацааны үнэлгээгээр нотлогдсон билээ. Люксембургийн Засгийн газар мөн ХДХВ/БЗДХ-аас сэргийлэх төслийг үргэлжлүүлэн дэмжиж, энэ төслийн хүрээнд НҮБ-ын Хүн амын сан,

Баруун талд: НҮБ-ын Хүн амын сангийн хамт олон, 2014 оны зун. НҮБ-ын Хүн амын сангийн ажилтнуудын ихэнх нь нийслэл Улаанбаатар хотод, харин цөөн хэдэн ажилтан сонгосон аймгуудад ажилладаг.

хамтран ажиллагч байгууллагуудынхаа хамт ХДХВ, бэлгийн замаар дамжих халдваруудын талаарх залуучууд, хөдөлгөөнт болон эрсдэлт хүн амын мэдлэгийг дээшлүүлэв.

Өөрсдийн хүчинд тулгуурласан, сэтгэлийн хаттай залуу хүн амыг төлөвшүүлэхийн тулд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны манлайлалын хүрээнд НҮБ-ын Хүн амын сан бусад түншүүдтэй нягт хамтран ажиллаж байна. Швейцарийн хөгжлийн агентлаг, Люксембургийн Засгийн газартай хамтран Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Залуучууд хөгжлийн 7 төв, Залуучуудад ээлтэй эрүүл мэндийн 7 клиникийг байгууллаа. Үндэсний болоод залуучуудын оролцоог өргөн хүрээнд хангах замаар залуучуудад чиглэсэн анхны бодлогыг боловсруулж байна.

Засгийн газар, парламент, иргэний нийгэм, хөгжлийн түнш байгууллагууд хамтран хүн ам ба хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэх урт хугацааны бодлого, стратегиудыг боловсруулахаа амлан 2013 онд баталсан Улаанбаатар тунхаглалыг

хэрэгжүүлэх зорилгоор НҮБ-ын Хүн амын сан Хүн ам, хөгжлийн талаар төрөөс баримтлах цогц бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэв. Энэ бодлогын үр дүнд эрх баригчид бодлого, шийдвэр гаргахдаа Монгол улсын хүн амын динамик хөдөлгөөн, залуучууд, эмэгтэйчүүд, ахмад настан зэрэг эмзэг бүлгийн хүн амыг түлхүү анхаардаг болох юм.

Энэхүү хүчин чармайлтынхаа хүрээнд Монгол дахь НҮБ-ын Хүн амын сан шинэ түншлэлийг бий болгон, хөтөлбөрүүдийнхээ хүрээнд шинэлэг санаачлагуудыг дэмжих замаар хүн бүрийг тэгш хамарсан өсөлт, хөгжлийг дэмжиж байна.

2014 онд НҮБ-ын Хүн амын сангийн хүрсэн амжилтуудын заримыг тоймлон танилцуулсан энэхүү тайлан Танд таалагдана гэдэгт найдаж байна. Ирэх онд НҮБ-ын Хүн амын сан залуучууд, эмэгтэйчүүдийн асуудлаарх шинэлэг санаачлагуудыг манлайлан дэмжиж, Монгол хүн бүр нөөц, бололцоогоо бүрэн дайчилж, хөгжиж дэвждэг нийгмийг цогцлоохын төлөө үргэлжлүүлэн ажиллах болно.



"Би 2003 оноос эхлэн НҮБ-ын Хүн Амын санд ажиллаж байна. Би энэ гайхалтай байгууллагын ажилтан болж, хийсэн бүтээсэн бүхэнд нь өөрийн хувь нэмрээ оруулсанаараа маш их бахархдаг." -Н. Жүгдэрсүрэн.

НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨР: ЖИРЭМСЛЭЛТ БҮР ХҮССЭН, ТӨРӨЛТ БҮР ЭСЭН МЭНД БАЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ

НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН хөтөлбөр нь хувь хүний өсөлт, хөгжлийн суурь болсон бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хангахад дэмжлэг үзүүлдэг. НҮБ-ын Хүн амын сан бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр, ялангуяа Улаанбаатар хотод онцгойлон анхаарч, бодлого, стратеги, журмуудыг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. НҮБ-ын Хүн амын сан бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц үйлчилгээний чанарыг сайжруулах шинэлэг санаачлагуудыг дэмждэг. Тухайлбал телемедициний сүлжээ, БЗДХ/ХДХВ-д өртөх эрдсэлт хүн амд хүрч үйлчлэх гэх мэт. Мөн залуучуудад ээлтэй үйлчилгээг бий болгох замаар залуучуудын эрүүл мэндийн хэрэгцээг хангахад онцгой анхаардаг.

НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХИЙГ ХАНГАХ ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ

Эрүүл мэнд, спортын яамтай нягт хамтран ажиллах замаар НҮБ-ын Хүн амын сан үндэсний бодлогын дараах баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэв. Үүнд: 1) Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам; 2) БЗДХ/ХДХВ-ын оношилгоо, эмчилгээний журам; 3) Үргүйдлийн оношилгоо, эмчилгээний заавар.

Эдгээр стратеги, журмуудыг боловсруулахад нь хамтран ажиллагч байгууллагууддаа дэмжлэг үзүүлсэн нь НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэг дээш чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаанд шилжсэний нэг тод илрэл бөгөөд энэ сацуу үр өгөөжтэй хэрэгжилтийг хангах Засгийн газрын үүрэг хариуцлага өсөн нэмэгдэж байна.

ХЯТАД, МОНГОЛ УЛС ХИЛИЙН БҮС НУТАГТ БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАР, ХДХВ-ИЙН ЭСРЭГ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Люксембургийн Засгийн газраас тууштай дэмжиж буй БЗДХ/ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх төслийн хүрээнд НҮБ-ын Хүн амын сан Хятадтай хиллэж буй бүс нутгуудад орон нутгийн ТББ-уудтай хамтран ажиллаж байна. Уг ТББ-ууд нь эмэгтэй биеэ үнэлэгчид, хүнд даацын тээврийн жолооч нар, уул уурхайн бүсэд шилжин ирсэн залуучуудад хүрч ажилладаг бөгөөд уг ажиллагаагаар дамжуулан Монгол, Хятадын хилийн бүс нутгуудад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөвлөгөө, үйлчилгээг анх удаа зохион байгуулав.

ЭХИЙН ЭНДЭГДЭЛ БУУРСААР БАЙНА

Эмнэлгүүдийн статистик мэдээллээс үзвэл 2014 онд Монгол улсад эхийн эндэгдэл буурсаар түүхэнд хамгийн бага буюу 100,000 амьд төрөлтөд 30.6 болов. Телемедициний сүлжээг ашиглан эх, нярайн эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулж, эхийн эндэгдлийг бууруулахад Люксембургийн Засгийн газар НҮБ-ын Хүн амын сан Монгол Улсын Засгийн Газарт санхүүгийн дэмжлэгийг тасралтгүй үзүүлсээр ирлээ.

“Би Сүхбаатар аймагт амьдардаг. Миний цусны даралт маш өндөр тул намайг дутуу төрөх, өөр бусад хүндрэл гарах эрсдэлтэй гэж эмч анхааруулсан. Аймгийн эмнэлэгт үзүүлсэн боловч үр дүн нь тодорхойгүй байсан. Харин Телемедициний сүлжээг ашиглан эмч маань нийслэл хотын (Улаанбаатар) эмч нараас зөвлөгөө авсан ют... Өнөөдөр би эрүүл, аз жаргалтай байна. Миний болон хүүхдийн маань амийг аварсан бүх эмч нартаа баярлалаа”- Телемедициний сүлжээгээр зөвлөгөө авсны үр дүнд эндэлгүй, эсэн мэнд амаржсан Монгол эх

Одоо бүх аймгууд энэхүү сүлжээнд холбогдоод байгаа бөгөөд үүний үр дүнд эмэгтэйчүүд эмчлүүлэхээр нийслэлийг зорих шаардлагагүй болж, ЭХЭМҮТ-ийн гурав дахь шатлалын нарийн мэргэжлийн чанартай зөвлөгөөг орон нутагтаа цаг алдалгүй авч, эсэн мэнд амаржиж байна.

ЦАХИМ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНД ЭХ БАРИГЧ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМЧ НАРЫН УР ЧАДВАР САЙЖИРЧ БАЙНА

Монгол дахь мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвтэй (ЭМХҮТ) хамтран НҮБ-ын Хүн амын сан болон Люксембургийн Засгийн газар орон нутгийн эмч нарт зориулсан цахим сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох ажлыг дэмжив. Энэхүү санаачлага нь орон нутгийн эмч нарыг мэргэжлээ тогтмол дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой. Төслийн хүрээнд эх барихын чиглэлээр (1) цус алдалтыг зогсоох, (2) жирэмсний үеийн цусны даралт ихсэлт, манас таталтын урьтал, (3) сепсис гэсэн 3-н модулийг агуулсан 4 долоо хоногийн хугацаатай, магадлан итгэмжлэгдсэн, зайн, цахим сургалтын хөтөлбөрийг (<http://elearning.obgyn-telemedicine.mn/>) боловсруулан, хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрийн эхний хэсгийг 11 дүгээр сарын эхээр зохион байгуулж, улс орон даяар 181 эмч, мэргэжилтэн үүнд хамрагдав.

ХУВЬ ХҮНИЙ НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХЫН ТУЛД ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТ, НЭН ЧУХАЛ ЭМ, ХЭРЭГСЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ НЬ

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг хувь хүмүүст хүртээмжтэй хангахын тулд НҮБ-ын Хүн амын сан болон Эрүүл мэнд, спортын яам хамтран Улаанбаатар хотын (бүх аймгуудад өмнө нь уг системийг нэвтрүүлсэн) бүх дүүрэгт ложистикийн удирдлагын CHANNEL системийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэв. Энэхүү систем нь эм, хэрэгслийг тасралтгүй хангах үр ашигтай төлөвлөлт хийж, хувь хүн бүрт нэн чухал, гэр бүл төлөвлөлтийн эм, хэрэгслийг хүртээмжтэй болгодог. Энэ нь Улаанбаатар хотод нөхөн үржихүйн эм, хэрэгслийн тасралт өндөр хувьтай байгааг шийдвэрлэхэд чиглэсэн НҮБ-ын Хүн амын сангийн хариу арга хэмжээ юм.

Жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл, эх, нярайн амийг аврах чухал хэрэгцээний эм, гэр бүл төлөвлөлт, эхийн эрүүл мэндийн үйлчилгээ, ХДХВ болон бэлгийн замаар дамжих бусад халдвараас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай эм, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүртээмжийг сайжруулахад чиглэсэн Нөхөн үржихүйн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамжийн стратегийг 2014 онд боловсруулсан бөгөөд удахгүй батлагдах гэж байна. Тус стратегийг 2015 оноос эхлэн хэрэгжүүлэх юм.



ЖЕНДЭРИЙН ХӨТӨЛБӨР: ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД, ЭРХ ТЭГШ НИЙГМИЙГ ЦОГЦЛООХ НЬ

Жендэрийн хөтөлбөр нь жендэрийн үндэсний тогтолцоог бэхжүүлж, жендэрийн тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх шинэлэг үйл ажиллагааг дэмжих зорилготой. Энэхүү зорилгод хүрэхийн тулд жендэрийн тэгш байдал, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хууль боловсруулж хэрэгжүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсөв боловсруулах талаар улс төрчид, төрийн холбогдох байгууллагуудын мэдлэг/туршлага хуваалцах явдлыг НҮБ-ын Хүн амын сан дэмжив.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ ДЭМЖИХЭЭ АМЛАВ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж 2013 онд эхлүүлсэн “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг нэгдэцгээе!” аянаа үргэлжлүүлэн 2014 оны 3 дугаар сарын 6-ны өдөр НҮБ-ын “АМЛАЛТ” санаачлагад нэгдэж гарын үсэг зурав.

Монгол Улсын Ерөнхийлөгч НҮБ-ын “АМЛАЛТ” санаачлагад гарын үсэг зурсанаар охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохоо амлаж “Миний бие, Цахиагийн Элбэгдорж, гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг хэмээн үзэж, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага тооцон, гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалж, цогц үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчинг бий болгохын төлөө бодлого боловсруулагч нартай хамтран ажиллана” гэж мэдэгдсэн юм.

ЖЕНДЭР, ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ ЭЛЧ НАР УИХ-ЫГ “УЛБАР ШАР” БОЛОХОД ТУСЛАВ

Жендэр, хүний эрхийн төлөөх элч болох УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг, УИХ-ын гишүүн Д.Батцогт нар 12 дугаар сарын 25-ны өдрийн УИХ-ын чуулганыг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг шинэчлэн, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох Оранж буюу улбар шар өдөр болгон тэмдэглэв. Энэ өдөр УИХ-ын гишүүд НҮБ-ын Хүн амын сангаас гардуулсан улбар шар өнгийн ороолт, зангиагаар ижилссэн юм. Элч нарыг жендэрийн тэгш байдлыг сурталчлах, төсвийн шинэтгэлд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэхэд нь НҮБ-ын Хүн амын сангаас дэмжлэг үзүүлэв. Монголын түүхэнд анх удаа гэр бүлийн хүчирхийллийг

гэмт хэргийн ангилалд оруулах гэж байна. Хуулийг шинэчлэн, өргөн барихад хэдэн жилийг зарцуулсан юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТИЙГ (ЖМТ) НЭВТРҮҮЛЭХ АЛХАМУУДЫГ ХИЙЖ БАЙНА.

НҮБ-ын Хүн амын сан Засгийн газартай нягт хамтран ажиллаж, холбогдох албан тушаалтнуудыг сургалтанд хамруулж, ЖМТ-ийн удирдамж, сургалтын гарын авлага боловсруулсан бөгөөд энэ нь орон нутаг, төр болон улсын төсвийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн боловсруулахад чухал ач холбогдолтой юм.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА (ИНБ)-ААС ЗАСГИЙН ГАЗАРТ САНАЛАА ХҮРГҮҮЛДЭГ МЕХАНИЗМЫГ БИЙ БОЛГОХОД НҮБ-ЫН ХҮН АМЫН САН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭВ

ИНБ-ууд засгийн газарт саналаа хүргүүлдэг үр ашигтай механизм НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр бий болов. Жендэрийн тэгш байдал, хүний эрхийн чиглэлээр ажилладаг ИНБ-уудын нэгдсэн “МОНФЕМНЕТ” үндэсний сүлжээнээс хүн ам, хөгжлийн үндэсний цогц бодлогод жендэрийн дүн шинжилгээ хийв.

“МОНФЕМНЕТ” үндэсний сүлжээнээс хийсэн нарийвчилсан дүн шинжилгээ нь хүний эрхийн зарчмуудыг уг бодлогын баримт бичигт тусгах зорилготой байсан юм. Зөвлөмжүүдийг “Эмэгтэйчүүдийн нүдээр” үндэсний чуулганы үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, УИХ-ын эмэгтэй гишүүдийн бүлэгт танилцуулж, УИХ-д өргөн бариад байгаа Төрөөс хүн ам, хөгжлийн талаар баримтлах цогц бодлогын эцсийн хувилбатр тусгаад байна.

12-р сарын 25-ны өдрийн чуулган дээр УИХ-ын гишүүд улбар шар өнгөөр ижилсэж, “Хүчирхийллийг таслан зогсоохын төлөө нэгдэцгээе” аянд нэгдэж байгаагаа илэрхийллээ. Монголд гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоохын төлөө УИХ-ын гишүүд нэгдээд байгаа юм.



АЙМГУУДАД НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГУРВАН ТӨВ ШИНЭЭР БАЙГУУЛАГДАЖ, ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БАЙНА

Говь-Алтай, Завхан, Улаанбаатарт Нэг цэгийн үйлчилгээний хоёр төв байгуулахад НҮБ-ын Хүн амын сан дэмжлэг үзүүлэв. Эдгээр төвүүд нь хүчирхийлэлд өртөгсдөд эрүүл мэнд, бие махбодь, сэтгэл зүй, хууль эрх зүйн зөвлөгөө, хамгааллын үйлчилгээг цогцоор нь үзүүлдэг. 2014 оны хоёрдугаар хагаст, уг төвүүд 100 гаруй хохирогчдод үйлчилсэн байна. Төв тус бүр гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг 24 цагийн хамгаалах байраар хангаж, утсаар холбогдсон хохирогчдод нэг цэгээс цогц үйлчилгээ үзүүлдэг.

НҮБ-ын Хүн амын сантай хамтран Японы Засгийн Газрын буцалтгүй тусламжийн “Өвсний үндэс” хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Сүхбаатар дүүрэгт Нэг цэгийн үйлчилгээний төвийн өргөтгөлийг хийв. Үүний үр дүнд тус төв илүү олон хүнд үйлчлэх хүчин чадалтай болсон юм. Төвүүдийн тогтвортой ажиллагааг хангах явдлыг орон нутгийн засаг захиргаа бүрэн хариуцаж байна.

ЭМЭГТЭЙ УДИРДАГЧИД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХАРЬЦАХ СУРГАЛТАНД ХАМРАГДАВ

НҮБ-ын Хүн амын сан, Жендэрийн үндэсний хороо, олон улсад нэртэй CDC буюу “Хөгжлийн харилцаа төв” хамтран Монголын 12 эмэгтэй удирдагчид түүний дотор УИХ-ын гишүүд, сайд, дэд сайд нар болон бусад нөлөө бүхий эмэгтэйчүүдэд зориулан сургалт зохион байгуулав. Сургалтанд оролцогчид ганцаарчилсан зөвлөгөө авч 5 өдрийн сургалтын үеэр хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцах ур чадвар эзэмшив.

ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХОД УРАН БҮТЭЭЛЧИД НЭГДЛЭЭ

Сар бүрийн 25-ны өдөр оранж буюу улбар шар өнгөөр ижилсдэг “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын төлөө нэгдэцгээе” хэмээх НҮБ-ын аяны хүрээнд Монгол дахь НҮБ-ын Хүн амын сан монгол уран бүтээлчидтэй хамтран шинэ арга хэмжээнүүд зохион байгуулав. Авъяасаараа монголчуудын анхаарлыг татсан алдартай уран бүтээлчид, шинээр гарч ирж буй залуу уран бүтээлчид Монголыг хүчирхийллээс ангид болгохын төлөө нэгдсэнээрээ энэхүү арга хэмжээнүүд онцлог юм.

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР: МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫГ ЧАДАВХИЖУУЛАХ НЬ

Залуучуудын хөгжлийн хөтөлбөр нь залуучуудыг эерэг бодолтой, хариуцлагатай, бие даасан иргэд болгон төлөвшүүлэх амьдрах ухааны боловсролын чанарыг сайжруулах зорилготой. Энэ зорилгод хүрэхийн тулд НҮБ-ын Хүн амын сан төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, залуучуудын асуудлаар бодлого боловсруулж, батлуулах; зорилтот орон нутаг, байгууллагуудад амьдрах ухааны сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах; залуучуудыг чадавхижуулан, тэдний дунд хүчирхийллээс ангид орчинг бий болгох; залуучуудын хэрэгцээг хангасан эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлж байна.

2014 ОНД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН 7 ТӨВ , ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЭЭЛТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН 7 КЛИНИК БАЙГУУЛАГДАВ

Швейцарийн хөгжлийн агентлаг, Люксембургийн Засгийн Газартай хамтран НҮБ-ын Хүн амын сан, ХАХНХЯ Залуучуудын хөгжлийн 7 төв (ЗХТ)-ийг¹ амжилттай байгуулав. Эдгээр төвүүд нь залуучуудад эерэг зан үйлийг төлөвшүүлэх, мэргэжлийн хувьд өсч хөгжих, амьдрах ухааны ур чадвар эзэмшихэд нь дэмжих зорилготой. 2015 оны эцэс гэхэд шинээр 7 төвийг нээх юм.

Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн 7 клиник Улаанбаатар хот болон зорилтот аймгуудад үүд хаалгаа нээлээ. Бэлтгэгдсэн боловсон хүчин, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэлээр бүрэн хангагдсан эдгээр клиникууд нь залуучуудад эрүүл мэндийн талаарх санаа зовоосон асуудлуудаа хуваалцаж, эрүүл мэндийн мэдлэг, чадвараа дээшлүүлж, шаардлагатай үед хамгаалалт дэмжлэг авах боломжоор хангаж, үйлчлүүлэгчийн нууцыг хадгалсан, эелдэг, ээлтэй, мэргэшсэн үйлчилгээ үзүүлдэг.

МОНГОЛЫН ЗАЛУУЧУУД ЭРЧ ХҮЧТЭЙ БАЙНА !

Шинэ бүтээл, оновчтой санал гаргахыг 150 залуу сайн дурын ажилтанд уриалтал юу болов? Төсөөлөшгүй үр дүнд хүрээ! Мянга гаруй залуус TEDx, StartupWeekend, Social Good Summit гэсэн 3 том арга хэмжээнд оролцож, энэ талаар нийт 100,000 гаруй цахим сэтгэгдэл бичигдэж, мэдээний 30 гаруй сувгаар уг арга хэмжээнүүдийг мэдээлж, залуучууд дуу хоолойгоо шийдвэр гаргах дээд түвшинд хүргэв.

Энэ нь цаашлаад гайхалтай үр дүнд хүрч, Эрүүл мэндийн сайд 2015 оныг оюутны эрүүл мэндийг дэмжих жил болгон зарлаж, Улаанбаатар хотын захирагч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтийн тээврийг тэгш хүртээмжтэй болгохоо амлав. Энэ тухай дүрс бичлэг, хэлэлцүүлэгүүд Монголын залуучуудын дунд улам бүр түгсээр байна.

СУРГУУЛИЙН АЮУЛГҮЙ ОРЧИН САНААЧИЛГЫГ ТҮРШИВ

2014 онд НҮБ-ын Хүн амын сан, МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ хамтран жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх загварыг Баян-Өлгий, Өмнөговь, Завхан аймаг, Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн дөрвөн сургуульд туршив. Өнөөдрийг хүртэл уг туршилтын хөтөлбөрт 3,890 сурагч хамрагдаж, анги бүлгүүд эерэг үр дүнд хүрээд байна.

¹ Залуучуудын хөгжлийн анхны хоёр төвийн нэгийг 2012 онд Дорнод аймагт, нөгөөг нь 2013 онд Дархан-Уул аймагт байгуулсан.

Сургуулийн багш, ажилтан, сурагчид сургалтанд хамрагдаж, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдлэгээ дээшлүүлж, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцон, хүчирхийллээс ангид орчинг бий болгохыг зорьж, үүний үр дүнд тэдний хандлага ихээхэн өөрчлөгдөж, бүх хүнд ээлтэй, эвсэг орчин бүрдэж байна.

ШИНЭ НАЙЗ АЯНААР ХҮНИЙ АМЬ АВАРЛАА

Улс орон хурдацтай өөрчлөгдөж байгаа энэ үед залуучууд ар гэрээ орхин, ажил сургуулийн мөр хөөн, хот, суурин газар бараадаж, багагүй бэрхшээлтэй тулгардаг. Энэхүү хөдөлгөөнт орчинд НҮБ-ын Хүн амын сангийн Y-Peer буюу үе тэнгийнхний боловсролын хөтөлбөр Монголын хамгийн эмзэг, алслагдсан бүлгийн залуучуудад хүрч, тэдэнд сургалт явуулаад зогсохгүй, амь насыг нь аварчээ.


Үе тэнгийн сургагчид бол бусдад хүрч үйлчлэх, зөвлөгөө өгөх чиглэлээр бэлтгэгдсэн залуучууд бөгөөд тэд үе тэнгийнхэндээ дэмжлэг, туслалцаа үзүүлэхийн тулд олон нийтэд хүрч ажилладаг. Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүн амын сан “Шинэ найз” сэдэвт үе тэнгийнхний шинэлэг аяныг өрнүүлж, энэ аян нь хэдэн зуун залуучуудын амьдралд нөлөөлөв. Тухайлбал, хөдөөний нэгэн охин өөрт тулгарсан саад бэрхшээлээ даван туулах гэж зүдэрч явахад нь үе тэнгийн сүлжээний гишүүн-шинэ найз нь түүнд тусалж, аварчээ.

“ҮЕ ТЭНГИЙН СҮЛЖЭЭ НАМАЙГ АВАРСАН. ҮҮНД БИ ИХ ТАЛАРХАЖ ЯВДАГ” Оюука

ЗАЛУУЧУУДАД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ЯВДАЛЫГ ҮНДЭСНИЙ ТҮВШИНД АВЧ ХЭЛЭЛЦЭВ

2014 онд Дэлхийн хүн амын өдрийг тэмдэглэхдээ НҮБ-ын Хүн амын сан залуучуудад үр өгөөжтэй салбаруудад хөрөнгө оруулахыг Засгийн газарт уриалсан сурталчилгааг бэлтгэж, мэдээллийн 5 сувагаар, бүх орон даяар цацахад дэмжлэг үзүүлсэн юм. Уг сурталчилгаанд УИХ-ын 2 гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд оролцож, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахын сацуу хүчирхийллээс ангид аюулгүй нийгмийг байгуулахыг уриалав.

“МОНГОЛ УЛС БОЛ ЗАЛУУЧУУДЫН ОРОН. ИЙМД МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ БОЛСОН ЗАЛУУЧУУДАА ДЭМЖИЖ, ХАМТДАА ХӨГЖИЦГӨӨЕ.” – Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, дэлхийн хүн амын өдөрт



ХҮН АМ, ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР: ИРГЭН БҮРТ ХҮРЧ ҮЙЛЧЛЭХ НЬ

ХҮН АМ, ХӨГЖЛИЙН хөтөлбөр нь хүн амын нас, хүйсээр ангилсан, хамгийн сүүлийн үеийн тоон мэдээлэл түүний дотор хүн ам зүйн динамик хөдөлгөөн, залуучууд, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендэрийн талаарх тоон мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулалт, шийдвэр гаргалтад ашигладаг болгох зорилготой. Энэ зорилгод хүрэхийн тулд НҮБ-ын Хүн амын сан үндэсний бодлогуудыг боловсруулж, хэрэгжүүлэх, мөн хөгжлийн зорилгоор хүн амын тоон мэдээ, мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийн, ашиглахад дэмжлэг үзүүлдэг.

АМЛАСНЫХАА ДАГУУ ЗАСГИЙН ГАЗАР ТӨРӨӨС ХҮН АМЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ БОЛОВСРУУЛЖ, УИХ-Д ӨРГӨН БАРИЛАА.

2013 онд үндэсний дээд хэмжээний уулзалтаар баталсан хүн ам ба хөгжлийн асуудлаарх Улаанбаатар тунхаглалыг хэрэгжүүлж, Монгол Улсын Засгийн Газар Хүн ам, хөгжлийн талаар төрөөс баримтлах цогц бодлогыг батлуулахаар УИХ-д өргөн барив. Энэ бодлогоор Монголын хүн амын динамик хөдөлгөөнд дүн шинжилгээ хийж, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан зэрэг эмзэг бүлгүүдийг тодорхойлох юм. Энэ бодлогыг Засгийн газар 2030 он хүртэл суурь бодлого болгон ашиглана.

МОНГОЛЫН ТҮҮХЭН ДЭХ ӨРХИЙН ХАМГИЙН ТОМ СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ДҮНГ ТАНИЛЦУУЛАВ:

НҮБ-ын Хүн амын сан болон НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Үндэсний статистикийн хорооны хийсэн Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар өсвөр үеийнхний жирэмслэлт 15-19 насны 1,000 охид тутамд 44 болж нэмэгдсэн нь тогтоогдов. Энэ нь НҮБ-ын Хүн амын сан болон түүний түнш байгууллагуудыг өсвөр үеийнхний жирэмслэлт нэмэгдэж байгаад нэн даруй хариу арга хэмжээ авахад хүргэж байна. Урьдчилсан дүнгээс үзэхэд төрөлтийн түвшин олон жилийн дундажаас өндөр буюу нэг өрхөд 3.1 хүүхэд болжээ.

Гар аргаар мэдээлэл цуглуулахад гардаг алдаануудыг багасгаж, мэдээллийг богино хугацаанд цуглуулахын тулд анх удаа таблет ашиглав. Үүний үр дүнд мэдээлэл цуглуулах хурд нэмэгдэж, тоон мэдээ, мэдээлэл, дүн шинжилгээнд гардаг зөрүүнүүд ихээхэн буурсан юм. Хүн амын эрүүл мэндийн судалгаа, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгээр хийдэг нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, болон НҮБ-ын хүүхдийн сангийн дэмжлэгээр хийдэг хүүхэд-хөгжил гэсэн гурван бие даасан том судалгааг нэгтгэсэнээр НҮБ-ын агентлагууд

урьд өмнөх жилүүдтэй харьцуулахад зардлаа үлэмж хэмжээгээр хэмнэв. Энэ бол Монгол улсын түүхэн дэх хамгийн том судалгаа юм. Судалгааны эцсийн тайлан бүрэн эхээрээ 2015 оны эхээр хэвлэгдэнэ. НҮБ-ын Хүн амын сан мөн уг судалгаанд суурилсан гүнзгийрүүлсэн судалгаануудыг хийхэд дэмжлэг үзүүлж, залуу судлаачдад бүрэн боломж олгох юм.

МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БАЙГУУЛАГДЛАА

Хүн ам, өрхийн мэдээллийн санг Улсын иргэний бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сантай уялдуулах Үндэсний статистикийн хорооны санаачилгыг НҮБ-ын Хүн амын сангаас дэмжив. Энэ нь иргэний бүртгэл болон хүн амын үндсэн мэдээллүүд зөрөх явдлыг арилгахад чухал ач холбогдолтой. 2015 онд дунд хугацааны тооллого хийхдээ энэхүү санг мэдээллийн үндсэн сан болгон ашиглах юм.

ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БАЙГУУЛАГДАВ

Эрүүл мэнд, спортын яамны томоохон дэмжлэг, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тандалт судалгааны багийн нөр их хөдөлмөрийн үр дүнд эх, хүүхдийн эрүүл мэндийн тандалт судалгааны үндэсний тогтолцоо байгуулагдав. Энэхүү тандалт судалгааны тогтолцооны хүрээнд аймаг, сум бүрт нэг ажилтан, нийт 830 эрүүл мэндийн статистикч ажилтан дараах 4 үзүүлэлтээр тоон мэдээ, мэдээллийг тогтмол цуглуулах юм:

- Эхийн эндэгдэл
- Ноцтой хүндрэл
- Перинаталь эндэгдэл
- Төрөлхийн гажиг

МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН ХҮН АМЫН САНГИЙН ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС ШИНЭЛЭГ САНААЧИЛГУУДЫГ НЭВТРҮҮЛЭВ

ТУС САНД ХӨРӨНГӨ ХАНДИВЛАХ БАНКНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ БИЙ БОЛГОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

НҮБ-ын Хүн амын сангийн Нью-Йорк дахь төв удирдлага болон Монголын Худалдаа хөгжлийн банктэй хамтран Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн суурин төлөөлөгчийн газар вебсайтад суурилсан хандивын системийг нэвтрүүлж, ийм систем нэвтрүүлсэн дэлхийн цөөн хэдхэн суурин төлөөлөгчийн газруудын нэг боллоо. Энэхүү систем нь НҮБ-ын Хүн амын сангийн хөтөлбөрүүдэд хөрөнгө нөөц дайчлахад чухал ач холбогдолтой.

(www.unfpa-mn.org).

НҮБ-ЫН ХҮН АМЫН САН БҮТЭЭМЖЭЭ НЭМЭГДҮҮЛЭХИЙГ ЗОРЬЖ БАЙНА

2014 онд Монгол дахь НҮБ-ын Хүн амын сан график дизайн, хэвлэл, орчуулга, бичиг хэргийн хэрэгсэл ханган нийлүүлэгчидтэй урт хугацааны гэрээ байгуулж, бүтээмжээ нэмэгдүүлэв. Үүний үр дүнд НҮБ-ын

Хүн амын сан болон НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллагууд зардалаа хэмнээд зогсохгүй, илүү чанартай ажил, үйлчилгээг богино хугацаанд авдаг болсон юм.

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЛЭГ, ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭВ

Монгол дахь НҮБ-ын Хүн амын сан санхүү, хяналт, шинжилгээ үнэлгээ, худалдан авалт, үндсэн хөрөнгийн удирдлага, төслийн менежментийн талаар хэрэгжүүлэгч түнш байгууллагууддаа үе шаттай сургалт зохион байгуулав. Сургалт нь хэрэгжүүлэгч түнш байгууллагуудыг НҮБ-ын Хүн амын сангаас олгосон санхүүжилтийг тус сангийн дүрэм, журам болон Монгол улсын холбогдох хууль, бодлогын дагуу зарцуулдаг болгох зорилготой.

НЭГДСЭН ЗАРЧМААР АЖИЛЛАХ

НҮБ 2014 оноос мөнгөн шилжүүлгийн нэгдсэн зарчимын (МШНЗ) шинэчилсэн хүрээг хэрэгжүүлж, улс орны макро үнэлгээг 2013 онд хийж дууссанаар НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд хэрэгжүүлэгч түнш байгууллагууддаа микро үнэлгээ хийж эхлэв. МШНЗ-ын хүрээ нь хөгжлийн тусламжийг үндэсний тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулж, үндэсний удирдлага, хариуцлагын чадавхийг бэхжүүлж, 2005 онд батлагдсан Парисын тунхаглалд заасны дагуу үндэсний тогтолцоог ашиглан хандивлагчдын тусламжийг хүргэдэг тогтолцоонд аажмаар шилжихэд дэмжлэг үзүүлэх зорилготой.



НҮБ-ын Хүн амын сангийн шинэ стратеги төлөвлөгөөг улс орны түвшинд хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2014 онд Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн ажилтнууд тус суурин төлөөлөгчийн газрын тунхаг бичигт гарын үсэг зурав. Энэхүү тунхаг бичиг нь ажилтан бүр өөрсдийн ажил, зан харьцаа, ажлын гүйцэтгэл, мэргэжлийн ур чадвартаа анхаарч, бүгд хамтдаа, нэгдмэл уялдаа холбоотой ажилладаг болгох зорилготой юм.

2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТОВЧ ТАЙЛАН

НӨӨЦИЙН ХУВААРИЛАЛТ, ЗАРДАЛЫН ДҮН (АМ.ДОЛЛАРААР)

	Төсөв	Зардал	Үлдэгдэл	Гүйцэтгэл
Тогтмол эх үүсвэр	2,200,550	2,186,234	14,316	99%
Бусад эх үүсвэр	3,141,285	2,657,155	484,130	85%
Суурин төлөөлөгчийн газрын төсөв	499,169	497,965	1,204	100%
Бүгд	5,841,004	5,341,672	499,331	91%

БУСАД ЭХ ҮҮСВЭР: ХӨГЖЛИЙН ТҮНШ БАЙГУУЛЛАГУУДААС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ


Хандивлагч	Төсөв	Зардал	Үлдэгдэл	Гүйцэтгэл
Швейцарийн хөгжлийн агентлаг ¹	2,138,337	1,705,234	433,103	80%
Люксембургийн Засгийн Газар ²	522,304	492,268	30,036	94%
Люксембургийн Засгийн Газар ³	355,603	348,624	6,979	98%
Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн аюулгүй байдлыг хангах НҮБ-ын Хүн амын сангийн итгэлцлийн сан	125,041	111,028	14,013	89%
Япон Улсын Засгийн Газрын буцалтгүй тусламжийн “Өвсний үндэс” хөтөлбөр ⁴	86,000	N/A	N/A	N/A
Бүгд	3,141,285	2,657,155	484,130	85%

2014 ОНД ТОГТМОЛ ЭХ ҮҮСВЭРЭЭС ХӨТӨЛБӨРИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮДЭД ХУВААРИЛСАН САНХҮҮЖИЛТ


Жендэрийн тэгш байдал	325,000	307,078	17,922	94%
Хүн ам ба хөгжил	676,524	657,768	18,756	97%
Залуучуудын хөгжил	212,611	215,332	(2,721)	101%
Нөхөн үржихүйн эрүүл мэнд	670,534	678,306	(7,772)	101%
Хөтөлбөрийн зохицуулалт	312,500	327,750	(15,250)	105%
Бүгд	2,200,550	2,186,234	14,316	99%

Жич: (1) Залуучуудын хөгжлийг дэмжих төсөл
(2) Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих Телемедицин төсөл
(3) Залуучууд, хөдөлгөөнт хүн ам болон эрсдэлт хүн амыг БЗДХ/ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх төсөл
(4) Японы санхүүжилтийг Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газраар дамжуулан шууд шилжүүлэв.

2014 ОНД **ТОГТМОЛ ЭХ ҮҮСВЭРЭЭС** ОРЖ ИРСЭН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТ



2014 ОНД **БУСАД ЭХ ҮҮСВЭРЭЭС** ОРЖ ИРСЭН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТ



Жич: (1) Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих Телемедицин төсөл
 (2) Залуучууд, хөдөлгөөнт хүн ам болон эрсдэлт хүн амыг БЗДХ/ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх төсөл
 (3) Залуучуудын хөгжлийг дэмжих төсөл